



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй
дуудлагын худалдаагаар худалдах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 31,830,000.00 /гучин нэгэн сая найман зуун гучин мянган/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 3 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, "Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал З.Болдсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу байгууллагадаа төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтын хамт 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн
157 дугаар тогтоолын хавсралт

”Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв” улсын төсөвт
үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах автомашины жагсаалт

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, арал | Үйлдвэрлэсэн, ашиглагдсан, орсон он | Гүйлт, км (мянга) | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэх өртөг (төгрөг) | Сэргэн босголт (төгрөг) | Худалдах доод үнэ (төгрөг) |
|-----|---|-------------------------------------|-------------------|--|--|----------------------|-------------------------|--|
| 1 | Майти, 27-46 УБЗ, арал № KUPGA17FPVC117690 | 1997/2007 | 254,6 | 11,730,000.00 | 11,730,000.00 | 0 | 0 | 500,000.00 |
| 2 | Ниссан Элгранд, 62-26 УНД, арал № АТВЕ50 030940 | 2000/2009 | 320,3 | 12,600,000.00 | 12,600,000.00 | 0 | 0 | 500,000.00 |
| 3 | Соната-2, 51-03 УБА, арал№ КМНСF21DPTU585722 | 1996/2008 | 332,0 | 7,500,000.00 | 7,500,000.00 | 0 | 0 | 500,000.00 |
| | Нийт дүн | | | 31,830,000.00 (гучин нэгэн сая найман зуун гучин мянга) | 31,830,000.00 (гучин нэгэн сая найман зуун гучин мянга) | 0 | 0 | 1,500,000.00 (нэг сая таван зуун мянга) |